

## **160 Үгийг тунхаглах нь**

### **160.1 Үгийг тунхаглах**

Үгийг уншиж, сонсож, дуулгавартай дагадаг хүмүүс ерөөлтэй ээ

Үгийг тунхагладаг нь бүр илүү их ерөөгддөг. Түүний алдрын төлөө хэрхэн элбэг дэлбэг амьдрахыг заах нь таны үүрэг даалгавар юм. Дуулгавартай байх нь сонсогчийн үүрэг, мөн заах нь хаана ч илгээсэн байсан үйлчлэгчийн үүрэг юм. Хамгийн чухал ажил бол Үгийг тунхаглах явдал юм. Эш үзүүлэгчид шиг зүрх сэтгэлээ үргэлж бэлтгэж, гэмшиж, мууг эсэргүүц. Та ухралт хийж, гэмшихгүй байх үед гэм нүгэлд олзлуулна. Хамгийн эхний хийх зүйл бол гэмших, хоёр дахь нь гэмших. Үгийг дуулгаваргүй дагасаныхаа төлөө гэмшсэн зүрх сэтгэлийг Бурхан хайдаг.

Үгэнд бичсэн шиг цэвэрхэн сав байхыг эрмэлздэг хүмүүст Бурхан Өөрийн Сүнсийг цутгах болно.

Том байшинд олон сав суулга байдаг, зарим нь хүндэтгэлд, зарим нь ердийн хэрэглээнд зориулагддаг; Гэсэн хэдий ч, эзэн нь цэвэр савыг ашиглах болно; Үргэлж цэвэрхэн савыг бэлд.

Зөвхөн Бурханы Үг л зүрх сэтгэлийг өөрчилдөг. Эзний Сүнс ажиллахын тулд хамгийн түрүүнд Бурханых Үг байх ёстой. Өөрийн бодлыг бус Үгийг тунхаглах үед Эзэн хамгийн түрүүнд сонсдог. Зөвхөн Бурханы үг зүрх сэтгэлийг өөрчилдөг.

- Зөвхөн Бурханы Үг л бузар муугаас хамгаалдаг.
- Зөвхөн Бурханы Үг л бузар мууг ялна.
- Зөвхөн Бурханы Үг л сүнсийг дахин төрүүлдэг
- Зөвхөн Бурханы Үг гэмшил ба сэргэлтийг авчирдаг .

Дэлхийн үйлддэг шиг үр дүнгийн эцсийн үнэлгээг бүү хий. Харин цэвэрхэн сав бол.

Түүний үгийг тунхагла.

### **160.2 ҮГИЙГ ХЭРХЭН ТУНХАГЛАХ**

Мөргөж, магтан дуулж байх үед муу ёрын сүнснүүд зайлах бөгөөд мөн номлолыг сонсож байхдаа хүмүүс залбирлынхаа хариуг сонсох болно. Үг нь итгэл төрүүлдэг ба сонссон үг итгэл найдвар болдог. Номлолоо үргэлж ерөөлийн гэрчлэлээр өндөрлө: Үгийг дагахад хэнд ямар ерөөл ирсэн бэ? ; дуулгавартай байдал нь хотыг хэрхэн ялсан, ; дуулгавартай байснаар хүмүүс нэр төрөө хэрхэн сэргээсэн;дуулгавартай байдал нь ялалтыг хэрхэн авчирсан; дуулгавартай байх нь Ехова-Иреаг хэрхэн

авчирсан. Дуулгавартай байсан хүмүүсийг хувьд Үг хэрхэн ажилласан гэдэгт анхаарлаа төвлөрүүл. ("энэ нь зүрх сэтгэлд тань бичигдсэн ялалтууд юм")

Тунхаглахад анхаарлаа хандуул:

- Дуулгавартай байх нь ивээл ерөөлүүдийг авчирдаг
- Дуулгавартай байх нь алдагдсан хотыг сэргээдэг
- Дуулгавартай байх нь хүндэтгэлийг авчирдаг
- Дуулгавартай байх нь ялалтыг авчирдаг
- Дуулгавартай байх нь амьд Бурханы оршихуйг авчирдаг

### **160.3 ҮГИЙГ АРИУН СҮНСЭЭР ТУНХАГЛАХ**

Ойрхи Дорнод бол Библийн соёлын орчин талбар юм. Тиймээс Ойрхи Дорнодын соёл дунд сайн мэдээ нь теологийн лекц, эш үзүүлэлэг эсвэл дагалдах анхаарал татам шинж тэмдэгүүдээр бус Үгийн дээд өрөөний хүчээр тунхаглагдвал зохистой .

Сүнсийг ганхуулсан, сэтгэл хөдлөлд автсан бус Үгээр сүнснүүдийг булхуулж Бурханы хүчирхэг дагалдагчдыг сургаж чадах зориулалт гаргах ажилчдыг Ойрхи Дорнодын төлөө гаргаж ирэхийн төлөө залбирч, төлөвлө

Та Бурханы хайрыг Үг болон хуулиас уншдаг уу? Хэрэв танд хайр байгаа бол Шүүлтийн бүлгээс ч хүртэл хайрын тухай олж унших болно.

Та Үгийн тунхаглалаас Бурханы хүчийг харж байна уу ?

Та өөрийгөө Үгэн дотроос харж байна уу?

Та Үгээр дамжуулан амьд Бурхантай уулздаг уу?

Та Ариун Сүнсний дуу хоолойг Үгнээс сонсож байна уу?

Сайн хийх гэсэн уруу таталтанд бүү авт. Та Үгийг тунхаглах үед амьд Бурханы оршихуйг мэдэх ёстой. Бүү мэхлэгд!

Дэлхий ертөнцийн хуурамч зүйлээс болгоомжил! Чадвартай манлайлал эсвэл цэцэн цэлмэг байдал нь израильчуудыг үг хэл, боловсон яриагаар удирдаж чадаагүй. Харин Бурханы Сүнс ба Түүний тунхагласан Үгээр юм.

### **160.4 ХЭРХЭН НОМЛОХ , 5 МИНУТЫН ҮГ**

Номлол нь Үгийг сулруулдаг. Хэт их тайлбараас татгалз. Зөвхөн танил бус үгийн утгыг нь тодруул. Хүний яриа чихэнд сонсголонтой байдаг ч сүнс ба сэтгэлийг салгаж чадахгүй, үе мөч болон чөмгийг нэвтэлж чадахгүй; сүнсийг ч аварч чадахгүй.

Бурхан таньд юуг хэлж байна вэ? Үгийг уншиж, санаагаа тайлбарлаад “5 минутад дамжуул.” (Агуулгыг ойлгуултал давтаж, тайлбарла)

Үгийг номло, өөрийн үгийг биш, өөрийн бодсоныг ч биш харин Түүний үгнээс сонссон зүйлээ л номло.

Бүх үйлчлэлд Үгийг тунхагла. Үр дүнд нь хүмүүс амлалтаа дахин батлах болно; зүрх сэтгэлд нь итгэл нь өсч Бурханы үгийг сонсож байхдаа итгэл найдварыг олох болно.

Ертөнцийн үг яриа, зугаа цэнгэл, эсвэл гадаад тайлбар нь Бурханы үгийг сулруулдаг; Нэмэлт тайлбар хэрэгтэй байж болох үгсийг л тайлбарла. Бурхан энд юу хэлж байгааг тодруулж, төгсгөлд нь Бурханы үгийг дуулгавартай дагасан талаарх бичигдсэн ивээлийн талаар гэрчлэн ярь.

### **160.5 "МИНИЙ" ХААНЧЛАЛЫГ БАЙГУУЛ**

“Үнэнээр, үнэнээр, Надад итгэдэг хэн бүхэн Миний хийж байгаа ажлуудыг бас хийх болно гэж Би та нарт хэлье. Би Эцэг рүү явж байгаа учраас эдгээрээс ч илүү агуу зүйлсийгс Бурхан хийх болно. Есүс илүү сайн ертөнцийг биш харин Хаанчлалаа байгуулахын тулд ирсэн. Ехова бол Бүтээгч Бурхан бөгөөд Түүний хэлснийг дуулгавартай дагах нь Хаанчлалыг нь байгуулж буй явдал юм.

Түүний Хаанчлалыг бүтээх хүмүүсийг дэлхийгээс хамруулж үнэнийг зааж, тунхагла. Үнэн бол амьд бөгөөд Ариун Сүнс хэзээ ч ажиллахаа зогсдоггүй. Бурхан хариулттай залбирал, Үгийг дуулгавартай дагах байдлаар дамжуулан Хаанчлалыг байгуулдаг.

"Хүсэл тань биелж, Таны хаанчлал ирэх болтугай" гэсэн нь Есүс Христийн бүх шавь нарын амьдрах шалтгаан, зорилго байх ёстой. Сайн мэдээг түгээхийн төлөө чадваржиж, эргэн тойрныхоо хүмүүст үйлчилж гэрлээ гэрэлтүүл.

Бурханы Үгийг ойлгоогүй таны итгэдэг хэн нэгэн эсвэл хамт ажиллагсдаас **сүйрэл** ирж магадгүй боловч энэ нь энэ ертөнцийн хяналт, нөлөөн (нөлөөллийн суваг) дор байдаг. Тэд ордоноо шударга бус байдал, дээд өрөөнүүдийг булхайгаар барьж, эх орон нэгтнүүдээ хөлсгүйгээр хөдөлмөрлүүлж байна. Эдгээр зүйлс нь цаг нь болохоор сүйрэл авчирна.

### **160.6 ТА ЮУ Ч ГУЙСАН ТҮҮНИЙ ХҮСЛИЙГ ТОГТООХ**

Түүний үгийг тунхаглах үед Ариун Сүнс ажилладаг. Номлохдоо Ариун Сүнсний зөвлөгөөг сонсох цаг гарга.

Ехова Бурханыг мэдэхийн баяр баясгаланг олж мэдэр. Та зүрх сэтгэлийнхээ угт Бурханыг мэдэхийн баяр баясгалангаар дүүрэн байх үед “Хэрэв чи Миний дотор байж, Миний үгс чиний дотор байвал хүссэн зүйлээ гуйвал биелэх болно ” гэсэн нь үнэн болох болно.

Санаа зовох хэрэггүй, харин энэ нөхцөл байдалд Бурханаас хаана байгааг асууж, Тэр хэрхэн ажиллах, мөн Түүний хариултыг хүлээ.

Болгоомжтой, хянамгай, анхааралтай байж ялгаж салга.

Ажлаа дээд цэгт тавьж байгаа мэт бясалга. Усан дээр өндөр барилга шинэ хот барьж буй мэт ажилдаа төвлөр. Зураг төслөө шалгаж, дахин шалгана уу. Болзошгүй нөхцөл байдлыг бүгдийг Бурханы Үг дээр үндэслэн сайтар төлөвлө.

Төгсөлтийн дараа Бурханы хүч өгдөг сургууль байна уу? Хүн Бурханыг хөдөлгөдөг ном бичсэн үү? Зөвхөн итгэлээр тунхагласан Түүний Үг нь л Бурханыг хөдөлгөдөг.

Тэрээр дуулгавартай байдал, Ариун Сүнсний хүртээлээр л Хаанчлалаа байгуулсан.

Бурханы ажил хүний стратегиар бус дуулгавартай байх замаар хийгддэг. Тэрээр стратегиа Өөрийн цагт хүмүүстээ өгдөг.

Бурхан биш харин хүмүүс теологийг зохиож; тайлбар санал болгох боловч Түүний хүчийг харуулж чадахгүй .

Тиймээс бидэнд тэнгэрээс Ариун Сүнсээр заадаг чадварлаг номлол (үндсэн теологи) хэрэгтэй.

### **160.7 ЗҮРХ СЭТГЭЛЭЭ УУДАЛ**

Би номлохдоо зүгээр л өгүүлбэр эсвэл бичвэр дамжуулдаг уу? Эсвэл зүрх сэтгэлээ зориулдаг уу ?

Би теологийн хувьд сайн тайлбарлаж чадаж байна уу?

Би өөрийнхөө мэдлэг, хөдөлмөрөөр эсвэл өөрийн хүчээр бүтсэн туршлагаар хичээж байна уу ?

Би бусдад өөрийн мэдрэмжээ хэлж байна уу?

Та юунд хүрэхийг хүсч байна вэ?

Та өөрийгөө харуулахыг эсвэл Их Эзэний хүчийг харахыг хүсч байна уу?

Та Үгийг нэмж эсвэл хасахгүйгээр тунхагладаг уу?

Сурган заахдаа зүрх сэтгэлээ бүрэн зориул.

Номлохдоо зүрх сэтгэлээ хандуул.

Бичихдээ зүрх сэтгэлээ гарга.

Хичээл зүтгэлдээ сэтгэлээ гарга.

Хаана ч явсан зүрх сэтгэлээ зориул.

Тунхаглахдаа зүрх сэтгэлээсээ ханд, Бурханы хүч тэнд байх болно,

Ариун Сүнсний илрэл тэнд байх болно

Бурхан дээд тэнгэрт оршдог бөгөөд даруухан болон гэмшсэн сүнстэй хамт байна.

Тиймээс, гэмшиж, Түүнийг өдөр тутмын амьдралдаа урь.

#### • Хамгаалалт

Бодол санаа, оюун ухаан, үйлдлээ нэг бүрчлэн гэмш.

Дараа нь бүх нөхцөл байдалд Түүнийг үргэлж урь.

#### • Гомдол

Зоригтой байж, санаа зовох зүйлгүй бай. Сэтгэл хөдлөлд бус Үгэнд итгэ.

Түүний үгсийг итгэлтэйгээр тунхаглах үед Тэр үйлдэх болно гэдгийг мэд. Түүний үгийг болон амлалтыг тунхаглахаасаа өмнө өөртөө сануул .

### **160.8 ЭШ ҮЗҮҮЛЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?**

Түүний үгэн дээрх Бурханы хүсэл зоригийг бий болгохын тулд биднийг хөтлөхийн тулд эш үзүүллэг өгсөн. Тиймээс энэ нь сайн, амжилттай байх эсвэл илүү сайн амьдралыг бий болгохын тулд бус харин Түүний хаанчлалыг байгуулахын төлөө юм.

Дуулгавартай байх уу, эс дуулгавартай байх нь таны сонголт. Эш үзүүллэгийг дорд бүү үз. Харин ухаарлын чихээр сонсох нь ялалтад хүрэх зам юм. Ухаантай бай.

Хүмүүсийн тааллаар бус Түүнтэй хамт ажиллах Бурханы хүслийн дагуу Үгэнд үнэнч , итгэлтэй байх хүмүүсийг Бурхан ялгадаг.

### **160.9 ЭШ ҮЗҮҮЛЛЭГИЙГ ЯЛГАХ**

Хэлсэн, хийсэн зүйл ба итгэлээр эсвэл итгэлгүйгээр гэдгээс хамаарч Бурханы шүүлт эсвэл шагнал байх болно гэж Бурхан хэлсэн.

Та бүх зүйлийг итгэлээр Үгийн дагуу хийдэг үү?

Та анхны хайртайгаа ажилласан уу?

Та хэлсэн үгэндээ эзэн болдог уу?

Хэрэв эш үзүүллэг нь илүү сайн хоол хүнс эсвэл илүү сайн амьдралын төлөө байгаа бол Сатанаас гаралтай.

Хэрэв Түүний Хаанчлалыг байгуулахын төлөө, гэмшилд уриалсан мөн Түүний хаанчлалыг байгуулах замыг харуулж байгаа бол Еховагаас үүдэлтэй.

Жижиг зүйлийг хэрхэн гүйцэлдүүлэх, жижиг зүйлд үнэнч байх; шиврээ бороог аадар болгох, жижиг хот Ай хотыг алдсныхаа дараа хэрхэн бат цайзыг эзлэх талаар Бурхан зарц- эш үзүүлэгчдээрээ дамжуулан дэлгэрэнгүй ярьдаг.

Дэлгэрэнгүй асуугаасай гэж Бурхан танаас хүсч байна. Гэвч харамсалтай нь олон хүн нарийн ширийн зүйлд анхаарлаа хандуулдаггүй, жижиг зүйлийн нууцыг мэдэхгүй, зөвхөн том зүйлийн араас дагаж; тэд шүтээнүүдээр бузарлагдсан байдаг.

Ерөөлийн эцсийн зорилго нь тав тухтай эсвэл сайхан амьдрахын тулд биш харин Түүний хаанчлалыг байгуулах. Эш үзүүлэгүүдийг үл тоомсорлож болохгүй. Бурхан бидний бүх үйл хөдлөл, үг хэллэг, үйлдлийг шүүх болно  
Тэр бидний итгэлийг ариун сүмд болон талбарт жинлэнэ.  
Хэрэв эш үзүүлэг нь зөвхөн хувийн сайн сайхан, сайн бизнес, хөгжил цэцэглэлтийг төлөө ярьдаг бол энэ нь Сатанаас ирсэн. Харин эш үзүүлэг нь Түүний алдрыг өргөжүүлж, Хаанчлалыг нь дэлхий дээр бэхжүүлэх чиглэл, удирдамжийг Бурханы хүүхдүүд өгч байгаа бол Ехова Бурханаас юм.

#### **160.10 БУРХАН ТӨСГӨЛИЙГ АГУУ БОЛГОДОГ**

Мэдлэг, туршлага, шалтгаан, мөнгө эсвэл эрүүл ухаан зэргээр итгэлийг худалдаж авах гэж бүү оролд. Дэлхий ертөнцтэй адил бодож, тооцоолж болохгүй, харин Бурханы тооцооллыг ашигла. Эхлэл нь сул дорой мэт байх ч Бурхан төгсгөлийг нь агуу болгодог. Тиймээс Абрахамын дуудлага нь даруухан байсан ч өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна.

Цаг үе нь муу юм! Болгоомжтой, анхааралтай, тэвчээртэй байгаарай.

Таныг яаруулж, хурдан үйлдэл хийхэд түлхэх замаар сатан устгах гэж уруу татдаг, Үйлдэл хийх зөв цагийг олж мэдээрэй. Бурханы ивээлийн боломжийг бүү алдаарай.

#### **160.11 НЭГ СЭТГЭЛ ГЭМШСЭН ҮЕД**

Сүнс гэмшиж, буцаж ирээд Бурханы жинхэнэ хүүхэд, Бурханы оршихуйд зогсох чадвартай болох нь үр дүн юм. Энэ нь Бурханы хайрын үйл ажиллагааны үр дүн. "Бие биенээ хайрла" гэсэн тушаалыг сахидаг хүмүүс бол Бурханыг хайрладаг хүмүүс. Олон хүн Эзэн минь, Эзэн минь гэж дууддаг ч зүрхнээсээ биш, зөвхөн амаараа үйлчилдэг. Цөлд байсан Баптист Иохан шиг тунхагла. Материаллаг ашиг эсвэл ашиг тус олохыг бүү эрэлхийл.

### **160.12 БУРХАНЫ АЖЛЫГ ХОЙШЛУУЛЖ БОЛОХГҮЙ**

Бурханы ажлуудад маргааш гэж үгүй. Тийм учраас та үйлчилж байгаа тэр хүнтэйгээ дахин уулзахгүй ч байж магад гэсэн хандлага бодолтой байгаарай: Бурханы хайр, Ариун сүнсний хүч чадал Тэр үед та нарын дээр байх болно.

Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах; Та өөрөө Бурханы хүч- нөмрөгөөр хувцасла. Сайн мэдээг тунхаглаж, өвчтэй хүмүүсийг эдгээж, дарлагдсан хүмүүсийг чөлөөлж, хоригдлуудыг чөлөөлж, Ариун Сүнсийг итгэлтэйгээр даган авралын жилийг тунхагла.

### **160.13 БЯЦХАН ОЧ БҮХНИЙГ ШАТААДАГ**

Ургамал мод ургахад хөрс шороо, ус, гэрэл шаардлагатай . Гэхдээ шатахын тулд тэдэнд гал хэрэгтэй. Бяцхан оч бүхнийг өдөөж байдаг. Буулт бүү хий, хүчтэй, зоригтой байж, урагш тэмүүл. Эзэн таньтай хамт байна.

Дэнгийн голыг асаахгүй бол гэрэл тусгаж чадахгүй . Асаж шатаагүй гэдэг нь туршлага үгүй гэсэн үг. Итгэлээр дамжуулан хэрэгжүүлээгүй Бурханы үг нь туршлага хуримтлуулахгүй. Асаж шатахгүйгээр Ариун Сүнснээс эсвэл өөр сүнснээс үү гэдгийг ялган таньж чадахгүй. Ариун Сүнсний гэрэл нь таны итгэлийн голоор тодоор гэрэлтэг!

### **160.14 МӨНХИЙНХӨД ТӨВЛӨРӨХ**

Мөнхийн зүйлд тохируулан бүх зүйлийг төлөвлөх мэргэн ухаантай бай. Хэрэв та Бурханы Үг дээр суурилагагүй бол, та дайсны талбар дээр барьж байгаа бөгөөд алах, хулгайлах, устгахаар ирдэг хүнээс өршөөл гуйж байна. Бурханы Үгэн дээр суурилагагүй бүх зүйл нуран унах болно.

### **160.15 ТҮҮНИЙ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЛИЙГ БИЙ БОЛГОХ**



Та олон хүнд өртэй. Өнөөдрийн таныг бий болгоход тань тусалсан олон хүний золиос зориулалтыг санаарай. Танд туслахаар хэн тэнд байсныг эргээд хар даа.

Таны одоогийн байгаа байранд байхад хэн нөлөөлснийг та харах ёстой.

Та өөрийн философийг үргэлж зөв, илүү дээр гэж үзэн бүгдийг өөрийнхөөрөө хиймээр санагдаж, хэлэлцэх хүсэлгүй, бүлэг доторх бусад хүнээс өөрийгөө дээр гэж үздэг бол та Бурхан ба хүний өмнө гол нүгэлтэн болно.

Бурханы ажлыг өөрийн арга замаар хийх гэж хичээх үед нүгэл орж ирэх болно.

Энэ нь Бурхан та хоёрын хооронд зааг бий болдог. Бурхан бол устгах биш, байгуулахыг хүсэж байна. Өөрийн мунхаглал, буруугаа гэмшин даруухан зүрх сэтгэлээр Эзэнд ойрхон ир. Түүний Үгийг өдөр шөнөгүй тунгаан бод.

Тахилын ширээгээ Абрам шиг байгуулагтун.

Ялалтыг өгдөг ивээлүүдийн Их Эзэнийг мэдэрч, та нарын төлөөх Түүний хүслийг ол.

### **160.16 ӨӨРИЙН БОДОЛ САНААГАА ҮГТЭЙ ТОХИРУУЛАХ**

Өгсөн үүрэг даалгавартаа үнэнч бай, учир нь манна өөр өөрөөр боловсордог шиг Үгийн тэмдэг, гайхамшиг, хүч өөр өөр байх болно. Үгийг зүрхэндээ л байлгаад байх нь үр жимс ургуулдаггүй харин үрийг нь тарьж, арчилж ургуулдаг. Тариалахгүй бол хураахгүй. Үгийг өөр лүүгээ биш харин өөрийгөө Үг рүү хандуул.

### **160.17 ҮГЭН ДЭХ БУРХАНЫ ХҮСЭЛД НИЙЦЭХ**

Таны үүрэг юу вэ: ахлагч, пастор, номлогч, эсвэл итгэгч үү? Та дуудлагыг хэр дуулгавартай дагасан эсвэл хүлээн дагаагүйгээрээ шүүгдэх болно. Үгэн дэх Бурханы хүсэлд дуулгавартай байж, түүнд анхаарлаа хандуулах хүмүүст Эзэн баярладаг.

Өөрийн удирдаж байгаа хүмүүст дуртай яа захирагд, дуулгавартай байдалд дурамжхан байх нь хагарал үүсгэдэг. Сургагдаж буй ажилчид ажиллах цаг улиралтай бөгөөд, удаа дараа хойшлуулж болохгүй. Сэтгэл хөдлөлдөө бүү автаж

урвай.Тууштай, зоригтой бай. "Өглөөний шүүдэр"- багийг өгөхийн төлөө Их Эзэнд хандан залбир. Бурхан газар дэлхийгээр хайж Бетлехемийн нутгаас Ефратын хүү, Давидыг олоод баярлаж байв.

### **160.18 ХҮҮХДИЙН ҮЙЛЧЛЭЛД ТӨВЛӨРӨХ**

Насанд хүрэгчдийнхээс илүү хүүхдийн төлөө үйлчлэлд түлхүү анхаар. Хүүхдүүдэд амьдралын дуудлага, зорилгыг мэдүүл.

Бурханы Үгэн дэх зөв замаар удирдаж, Түүнийг эргэж ирэхэд бэлтгэ.

### **160.19 ХҮҮХЭД ГЭР БҮЛ**

Сатан хүүхдүүд рүү дайрч, тэднийг ядрааж, биеийн өсөлт хөгжилтөд саад болдог.

Хүүхдүүд эрүүл өсөх ёстой ч Сатан довтолж хүүхдийн сэтгэл рүү дайрч, хоол тэжээлийн дутагдал, оюун ухаан муудах, дэлхийн садар самуун байдал, ядуурал, цөхрөл, уур хилэн зэрэгт өртүүлдэг.

Дайснууд өнөөдөр хүүхдүүд рүү юугаар яаж довтолж байна вэ? Бид яах вэ?

Олон мянган хүнийг хооллосон уулан дээрх гайхамшиг нь нэгэн хүүхэд талх, загасаа зориулан өргөсөн явдал юм. Янз бүрийн жимс ногооноос хүүхдүүдэд зөв шим тэжээл авдаг. Хүүхдүүдийн үйлчлэл хийж байхдаа хангалттай хоол тэжээлийг өгөөрэй. Тэдэнд шинэхэн барьсан талх, ундны цэвэр ус амин дэм болон Амьд Үгийг өгөөрэй.

### **160.20 МӨНХИЙН ТӨЛӨӨ СҮҮЛЧИЙН БОЛОМЖ**

Үхэхийг хүссэн ч чадахгүй, өвдөж шаналсан хэвээр байх нь шийтгэл ч, гэмшил ч аль аль нь юм. Үр жимс нь хүн гэмшиж, Эзэн рүү буцаж ирэх юм.

Төөрсөн нэгэнд үгийг дамжуулахад Ариун Сүнс таныг дагадаг. Гашуудаж буй зүрх хатуурсан зүрхийг зөөлрүүлдэг; Хайр дүүрэн зүрх нь хаалттай зүрхийг нээдэг.